

5

Хувцасны үйлдвэр



Эсгэх, оёх гэдэг бие махбодыг их ядраадаг ажил. Түүнээс гадна цалин бага, үйлдвэрлэлийн дамжлага хурдан, ажлын нөхцөл аюултай, үйлдвэрчний эвлэл дутмаг, ажлын байрны дарамт ихтэй гээд асуудал олон бий. (IV хэсэг. Нийгмийн аюул ба шийдэл)

Дэлхий дээрх бүх төрлийн хувцасны үйлдвэр нь ажилчдын эрүүл мэндийг хамгаалж, өндөр стандартыг мөрдөн ажиллах боломжтой. Эдгээр стандарт нь:

- Хүчтэй сайн агааржуулалт (17-р бүлэг), мэргэжлийн хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэглэл (18-р бүлэг).
- Галын гарц, гал унтраах усны шугам сүлжээ, гал унтраах хөөс болон галын үед хэрхэх талаар үйлдвэрээс зохиох сургалт, төлөвлөгөө. (11-р бүлэг)
- Үйлдвэрчний эвлэл, ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдлын хороог зохион байгуулах эрх чөлөөтэй байх (3-р бүлэг)
- Машин, тоног төхөөрөмжийг байнга засварлах, ажилчдад болон удирдлагын түвшинд эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдлын сургалтыг зохион байгуулах.
- Амьжиргаанд хүрэлцэхүйц цалин хөлс авах, нийгмийн ашиг сонирхлыг хуулийн хүрээнд ажилчдад хүндэтгэлтэйгээр ханган ажиллах. (19-р бүлэг)

Хүний эрхийн үндсэн заалтуудыг хэрэгжүүлэх нь зарим үйлдвэрийн хувьд маргаантай сэдэв хэвээр байна. Ажилчид, хэрэглэгчдийг үйлдвэрийн эзнээс дээрх эрхийг хэрэгжүүлэхийг шаардаж ялалт байгуулахад нь туслах, холбож өгөх, олон улсын байгууллагууд, үйлдвэрүүд (брэндүүд) болоод тухайн орны засгийн газруудтай энэ чиглэлээр гэрээ байгуулах нь одоогоор бэрхшээлтэй хэвээр байна.

Хувцас будах, химийн бодист оруулах үйл явц

Хувцасны үйлдвэрийн ажилчид бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхээс өмнө хувцасны даавуу, материалыг төрөл бүрийн химийн бодисоор будаж, галд тэсвэртэй болгож, зураг хээ хэвлэх зэрэг янз бүрийн чанарт хувиргадаг. Даавууг цайруулснаар илүү цагаан, амархан будагддаг болгодог. Дараа нь будагч бодисоор даавууг хүссэн өнгөндөө хувиргана. Бэхжүүлэгч нь даавуунд өнгийг тогтоох чадвартай. Нягтруулагч болон тогтворжуулагч нь даавууг угаах юм уу, норгоход будаг нь урсахыг багасгадаг.

Химийн бодис даавуун дээрээ үлддэг. Хэрвээ хувцас хийж байхад таны арьсан дээр тууралт гарч байвал тухайн даавууны будаг болон даавуунд хэрэглэсэн бусад химийн бодисоос болж байгаа юм.

Даавуу будагч бодис

Даавууны будаг, химийн бодис таны арьсыг цочроож, загатнуулж, тууралт, харшил үүсгэж, тэр ч бүү хэл амьсгалахад хүндрэлтэй болгодог.

Даавууны будагч бодистой харьцаж ажилласны дараа гараа уусгагчаар угаах нь мөн л тууралт, харшил, амьсгалын замын хүндрэл үүсгэдэг. Бензол болон бусад гоё үнэртэй химийн бодисоос хол байх хэрэгтэй. Эдгээр химийн бодисыг анхилуун үнэрт нүүрс-устөрөгчийн нэгдэл гэдэг бөгөөд амьсгалаар болон арьсаар нэвчиж хүний биед ордог. Үүнээс болж хавдар ч үүсэж болно.

Спиртийн (изопропанол гэх мэт) төрлүүд арай аюул багатай ч гэсэн ялгаагүй л арьсыг цочрооно. Тэртээ тэргүй л гар дээрх будгийг арилгахад хугацаа их ордог учраас оронд нь савантай усаар гараа угаасан нь дээр.



Зарим азо будагч бодисыг хавдар үүсгэдэг, эрүүл мэндэд хортой гээд хэрэглэхийг хориглосон. Будагч бодисын тухай 626-627 дугаар хуудаснаас уншина уу.

Даавуу, материал дээрх хэвлэл болон усны хамгаалалт

Формальдегид нь даавууг толигор болгож үрчийх, хунираа үүсэхийг багасгадаг бодис юм. Ажилчид даавууг формальдегид дүүргэсэн онгоцонд дүрэх юм уу, формальдегидийн хийгээр дүүргэсэн камерт даавууг оруулдаг. Зөвхөн үйлдвэрийн тухайн хэсэгт ажилладаг ажилчид формальдегидэд хордохоос гадна агааржуулагч муутай дэлгүүрт ажилладаг худалдагч нар хүртэл эрүүл мэндэд нь сөргөөр нөлөөлөх энэ бодист их бага хэмжээгээр хордож байдаг.

Формальдегид арьсыг цочроож улайлган загатнуулдаг. Түүнчлэн формальдегидийн манан, утаагаар амьсгалбал хамар, хоолой, уушгийг гэмтээдэг. Формальдегид нь астма, хавдар үүсэх шалтгаан болдог. (636-638 дугаар хуудсыг уншина уу.)

Галд тэсвэртэй болгодог химийн бодисууд

Хувцсыг галд тэсвэртэй болгохын тулд бромт гал унтраагч гэх мэт галаас хамгаалах химийн бодис хэрэглэдэг. Хэдий тийм боловч энэ химийн бодис нөхөн үржихүйн эрхтэн системийг өвчлүүлж, хавдар үүсгэдэг байна. 628-630 дугаар хуудсыг үзнэ үү.

Бактерийн эсрэг эмчилгээ

Хувцас дүрдэг ванн онгоцонд мөнгө, триклозан, триклокарбон хийнэ. Эдгээр бодис хувцсан дээр бактери үржихээс сэргийлж, үнэрийг нь дардаг. Ажилчид эдгээр бодисыг шингэн, нунтаг, үрлэн хэлбэрээр онгоцонд хийгээд халаадаг. Хувцсанд үлдсэн химийн бодис нь хэрэглэгчид гэртээ хувцсаа угаах тоолонд бага багаар хорогдон алга болдог.

Гэтэл мөнгө гэдэг бодис өөрөө эвдэршгүй чанартай байдаг учраас тодорхой хэмжээний аюул дагуулна. Энэ хор хуримтлагдсаар хүн, амьтан, ус болон газрын хөрсийг хордуулдаг.

Нано бичил хэсэг

Зарим химийн бодисыг нано бичил хэсэг буюу нано бөөм бүхий асар жижигхэн байхаар үйлдвэрлэдэг. Хувцсыг үйлдвэрлэсний дараа нано бөөмүүдийг даавуутай хамт ээрч эсвэл даавуун дээр түрхдэг. Хувцсыг бат бөх болгох, бактерийн эсрэг бүтэцтэй болгох, бохирдохоос хамгаалах, усны хамгаалалттай болгох, нарны гэрлээс хамгаалах, галд тэсвэртэй болгох гэх мэт олон зориулалтаар нано бөөмүүдийг хэрэглэдэг.

Нано бөөм нь маш өчүүхэн учраас арьсанд чөлөөтэй нэвтэрч, цусаар дамжин дотор эрхтэнд нөлөөлдөг. Ажилчид нано бөөмтэй харьцаж ажиллахдаа туйлын болгоомжтой байх нь зүйтэй. Мөн эрүүл мэндэд харшлахгүй ажлын орчныг бий болгох хувийн хамгаалах хувцас, агааржуулалтын хүчтэй систем гээд байж болох бүхий л шаардлагатай аюулгүй ажиллагааны хамгаалалтыг шаардах хэрэгтэй. Хэрвээ та нано бөөмтэй харьцаж ажилладаг бол дор хаяж хоёр давхар нийлэг эдээр хийсэн бээлий өмсөхийг зөвлөж байна. Гэвч ингэж бээлий өмсөөд ч хангалттай сайн хамгаалж чадах эсэхийг одоогоор хэн ч мэдэхгүй байгаа.



Эрүүл
мэндийн
мэдээлэл

Химийн бодисыг биеэс хол байлгах

Та биедээ химийн бодис орох, химийн бодист биеэрээ хүрэлцэх бүхий л тохиолдлыг бууруулаарай.

- **Гараа тогтмол угаа.** Ялангуяа хоол идэх, юм уух, тамхи татахын өмнө. Энэ үйлдэл химийн бодис таны биед амаар дамжин орохоос хамгаална;
- **Гараа зөвхөн савантай усаар угаа.** Ямар нэг уусгагч бодисоор гараа угаахаас зайлсхий;
- **Гартаа тос түрхэж бай.** Гараа угаасны дараа арьс хуурайшихаас сэргийлж тос түрхэж бай. Хагарч холцруутсан, улайсан арьсанд химийн бодис амархан нэвчдэг;
- **Урт бээлий өмсөж гараа хамгаал;**
- **Тухайн ажил, мэргэжилдээ таарсан хамгаалалтын бээлий өмс.** Ялангуяа даавуунд химийн бодис нэмэх ажил хийдэг бол илүү анхаараарай. (Бээлий, 344-348 дугаар хуудас);
- **Нүүрэндээ амны хаалт зүү.** Хэрвээ танд химийн бодис харагдаж, үнэртэж, мэдрэгдэж байгаа бол, агааржуулалтын систем сайн ажиллахгүй байгаа бол, ажилласан ч химийн бодисын хорыг гадагшлуулахаар хүчтэй биш байгаа бол заавал амны хаалт зүүгээрэй. (Амны хаалт болон амьсгалын аппарат, 349-354 дүгээр хуудас; 17-р бүлэг. Агааржуулалт хэсгийг уншина уу);
- **Ажил олгогчдоо хэл.** Яг аль даавуунд хүрэхэд арьс загатнаж, амьсгалахад хэцүү байгааг хэл. Ажил олгогч тань арьс загатнуулдаггүй, ямар нэгэн байдлаар эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй даавууг олж үйлдвэртээ хувцас оёулах ёстой.

Зөвхөн даавуу гэлтгүй хувцаснаас болж бас харшил, загатнаа үүсэж болно. Жишээлбэл, хувцсанд тогтоосон никель тав, товч зэрэг.

Хэрвээ таны арьс загатнаад байвал 218-219 дүгээр хуудаснаас загатнах зовуурийг хэрхэн намжаах болон бусад өвчний шинж тэмдгийн талаар уншиж танилцаарай.



Ажил олгогчоос шаардах зүйлс:

- Ажилчдын ойлгох хэл дээр тэдний хэрэглэж буй химийн бодисын тухай таних тэмдэг хийж, лекц зохион байгуулах, Хөдөлмөрийн аюулгүй байдлын бүртгэлийг ажилчдад үзүүлэх. (Тоон үзүүлэлтийн тухай 246-248 дугаар хуудаснаас уншина уу);
- Нийт ажилчдад химийн бодистой харьцаж ажиллахдаа мөрдөх аюулгүй ажиллагааны тухай сургалт хийх;
- Хувь хүний хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгслийг шийдэхээс өмнө эхлээд машин тоног төхөөрөмж, агааржуулалтыг сайжруул;
- Ажиллаж буй тухайн орныхоо ажлын байранд хэрэглэгдэх химийн бодисын тухай заалт бүхий хууль, дүрмийг зүй ёсоор сахиж мөрд.



Арьс загатнах, амьсгалахад хүндрэлтэй байх зэрэг мэдээллийг эрүүл мэндийн тэмдэглэлд бичиж хадгал. (70-71-р хуудаснаас уншина уу)



Эрүүл
мэндийн
мэдээлэл

Даавууг эсгэх, зүсэх



Огтлогч, эсгүүрийн машин нь ажилчдад нэн аюултай. Даавуу зүсэж, эсгэж байх үед ажилчид өөрсдөө гэмтэж, аюулд өртөхгүйн тулд дараах зүйлсийг анхаараарай:

- Машин, тоног төхөөрөмжийн хутганы гадуур тойроод хамгаалалтын давхарга байх ёстой. 264-266 дугаар хуудсыг үзнэ үү;
- Ажилчид металаар хийсэн торон бээлий өмсөж гараа хэрчүүлэхээс сэргийлэх хэрэгтэй. 348-р хуудсыг уншина уу;
- Ажилчдад машин, тоног төхөөрөмжийг аюулгүй ашиглах, ялангуяа яаралтай тохиолдолд хэрхэн машинаа унтраах талаар сургалт хийх ёстой;
- Ажилтан ямар нэг байдлаар бэртэх, зүсэгдэх тохиолдолд хэрэглэх зориулалттай анхны тусламжийн төлөвлөгөө, эм бинт гэх мэт хэрэгсэл үйлдвэр бүрт гарын дор байх ёстой. 272-274 дүгээр хуудаснаас машин, тоног

төхөөрөмжийн гэмтлийн үеийн анхны тусламж хэсгийг уншина уу;

- Мөн үйлдвэрүүд эрүүл мэндийн үйлчилгээ, эмчилгээ, сувилгаа болон гэмтсэн ажилчдыг нөхөн сэргээх, эмчлэх үйлчилгээгээр хангах шаардлагатай. Энэ үйлчилгээнд гэмтэл ослоос болж хөдөлмөрийн чадвараа бүрэн болон хэсэгчлэн алдсан ажилчид, тэдний гэр бүлд олгох нөхөн олговрын мөнгийг ч тусгаж өгөх ёстой байдаг.

Тоос ихтэй үйлдвэр дэх аюул

Ихэнх хувцасны үйлдвэрийн агаарт даавууны тоосжилт их байдаг бөгөөд энэ нь эрүүл мэндэд нэн хортой үзэгдэл юм. Гэхдээ тоос гэдэг шийдвэрлэхэд хялбар асуудал болно. Үүнд:

- Тухайн үйлдвэрийн агаарыг гадагшлуулах яндан бүхий агааржуулалтын систем нь агаарт буй тоос, тоосонцрыг зайлуулах боломжтой. (328-331 дүгээр хуудсыг үзнэ үү). 331-334 дүгээр хуудаснаас Агаар дахь тоос, тоосонцрын талаар авах арга хэмжээнүүд сэдвийг уншаад үйлдвэртээ ямар агааржуулалт ашиглахаа мэдэж авч болно. Үйлдвэрийн агааржуулалтын системийг шалгаж, засварлаж, тогтмол цэвэрлэж байх хэрэгтэй;
- Машин тоног төхөөрөмж ажиллаж байгаа орчинд илүү их тоос хуримтлагддаг. (231-р хуудсыг үзнэ үү);
- Ажлын орчноо байнга тоос сорогч, шалны мод, нойтон алчуураар цэвэрлэж байх ёстой. (294-295 дугаар хуудсыг үзнэ үү).

Хөвөн даавууны тоосонцроор амьсгалахын сөрөг талууд

Хөвөн даавуу болон бусад даавууны тоосонцроор амьсгалснаар дараах сөрөг үр дагавар гарна. Үүнд:

- Хамар хуурайших, загатнах;
- Тасралтгүй ханиалгах;
- Даавуутай ижил өнгийн нус гарах, хамраас ус гоожих;
- Амьсгал давчдах.

Удаан хугацаанд хөвөн даавууны тоосонцроор амьсгалаад байвал уушги тоосжих, биссиноз (byssinosis) гэх мэт уушгины хүнд төрлийн өвчнүүд тусдаг. Биссинозын шинж тэмдэг дараах байдлаар илэрнэ.



Эрүүл
мэндийн
мэдээлэл

(ургэлжлэл)



Эрүүл
мэндийн
мэдээлэл

- Цээж давчдах;
- Амьсгал хэржигнэх;
- Байнга бронхиттой байх;
- Ханиад хүрэх болон харшлын шинжтэй үзэгдлүүдтэй төстэй байдал.

Хэрвээ биед тань дээрх шинж тэмдэг илэрвэл таныг биссиноз болон уушгины өөр ямар нэг төрлийн өвчин туссан эсэхийг шалгаж чадах эрүүл мэндийн ажилтанд хандах хэрэгтэй.

Тамхи татахаа больж, тамхины утаанд ойр байхаас зайлсхий.

Гэрийн нөхцөлд биеийн тамирын дасгал, амьсгалын дасгал, шаар үлээх зэрэг аргаар өвчнөө түр намдааж болох боловч уг өвчнийг бүрэн төгс эмчилж чадахгүй.

Астма өвчний эмчилгээ хийлгээд биссинозын шинж тэмдгийг багасгах боловч өвчнийг уг үндсээр нь эмчилж чадахгүй. Биссинозын хүнд шатанд байгаа өвчтөнд хүчилтөрөгчийн аппаратаар эмчилгээ хийх хэрэгтэй болно.

Бид нөхөн олговор авахын тулд 15 жил тэмцсэн

Ажиллаж байсан оёдлын үйлдвэрийнхээ орчноос болж өвчилж байсан учраас бид Тайландын Ажил мэргэжил, Орчны нөлөөнөөс болж өвчин туссан өвчтөний зөвлөл (WEPT-TAOӨЗ)-ийг байгуулсан юм. Бидний хувьд хөвөн даавууны тоосонцроор амьсгалснаас болж амьсгалын замын өвчнөөр өвчилж, машин тоног төхөөрөмжийн чанга дуунаас болж сонсгол муудаж, бүүдгэр гэрэлтүүлэгтэй орчноос болж хараа муудаж байв.

Бидний ихэнх нь ажил мэргэжлээс шалтгаалах өвчин болох биссиноз туссан болохыг эмч тодорхойлсон юм. Эмчийн магадлагааг үндэслэн бид ажил олгогчтойгоо хийх тэмцлээ эхлүүлсэн. Үйлдвэрийн дарга агаарт тоосжилт ихтэйг мэдсээр байж биднийг хамгаалаагүй юм. Бид өмнө нь амьсгалахад хэцүү байна гэж хэлсэн боловч үйлдвэрийн дарга юу ч хийгээгүй. Үүний уршгаар бид өвчин тусаж, тэр нь биссиноз болтлоо хүндэрснийг мэдлээ. Ингээд бидний 200 хүн нийлж амь нас, амьдралынхаа төлөө тэмцэж эхэлсэн. Шүүхээс үйлдвэрийн удирдлага бидэнд өвчний нөхөн олговор төлөх шийдвэр гарлаа. Гэтэл үйлдвэрийн дарга төлбөр төлөх

бодолгүй байв. Ингээд бид 100 гаруй өөр өөр шатны шүүхэд давж заалдсан юм.


Арав гаруй жилийн дараа маш бага нөхөн олговор, хэдхэн цаасны тэтгэмж авсан. Бид ийм байдлаар цаашдаа амьдарч чадахгүй. Тиймээс бидний дундаас 37 хүн маань дахин тэмцлээ үргэлжлүүлэхээр шийдсэн юм.

Арван таван жилийн дараа 2010 онд Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Дээд шүүхээс ажил олгогч нь ажилчдад хангалттай хэмжээний нөхөн олговор төлөх шийд гарсан. Энэ мөнгө бидний амь амьдралаа аврахын тулд олон жил уйгагүй шүүхээр явж зовсон тэр зовлонг хэзээ ч нөхөхгүй, бидний эрүүл мэндийг буцаан авчирч чадахгүй. Гэлээ ч гэсэн энэ бол бидний хувьд том ялалт байсан. Олон олон ажилтан биссиноз өвчин туссан боловч эмчээр оношоо тогтоолгоогүй учраас ажил олгогч нар нь хариуцлага хүлээхээс татгалздаг. Бидний энэ ялалт, биднийг шүүхээр явж тэмцэл өрнүүлээд амжилтад хүрч болно гэдгийг баталж өгсөн.




ТАОӨЗ ажилчдынхаа төлөө тэмцэнэ!
Ажилчид тэмцэж, ялж чадна!

Оёдол



Оёдлын машинаас болж үүсэх гэмтэл: Оёдлын машины зүү таны гар хурууг эсгэж, гэмтээгээд зогсохгүй нүд рүү ч үсэрч орох аюултай. Хувцасны хэсгүүдийг нийлүүлж оёж байхад үс зулгаагдаж оёгдох, бүр цаашилбал бүхэл биеийг машин руу татан оруулах аюултай.

- Машины хамгаалалтын шил нь (хуванцар ч байж болно) оёдолчдыг зүүнд хатгуулах, зүсэгдэх, гэмтэхээс хамгаалдаг. (262-266 дугаар хуудсыг уншина уу.)
- Машинд оёж байгаа хэсгээ хөдөлгөхдөө ханцуй, үс, бүс, хувцас зэргээ аль болох оёдлын машинд хамт оруулахаас болгоомжлон анхаарч ажиллаарай. (262 дугаар хуудсыг уншина уу.)



Булчин шөрмөсний гэмтэл: Оёдолчин нэг үйлдлээ дахин дахин давтан хийдэг. Нэг үйлдлээ олон давтан хийснээс болж гэмтэл авахгүйн тулд:

- Ажлын хооронд амарч, биеийн бүх хэсгийн булчинг амраан сунгалтын дасгал хий;
- Оёдлын машин, багаж хэрэгслээ өөрөө гар хүрэхэд ойрхон, өргөхөд хөнгөхөн байхаар нөөц боломж, хүч чадалдаа тохируулан бодож ажлын орчноо тохижуул. (7-р бүлэг. Эргономик)

Дуу чимээ: Оёдлын болон тавлагч машинууд дуу чимээ ихтэй байдаг. Хэрвээ олон машин зэрэг ажиллаж байгаа бол бүр ч их дуу чимээ гарах нь ойлгомжтой. Энэ их дуу чимээ хүний сонсголыг муутгадаг.

- ХАБЭА-н ажилтнаар дуу чимээний түвшингээ тодорхойлуул;
- Хэрвээ дуу чимээний түвшин өндөр байвал чихэвч зүү. (355-357 дугаар хуудсыг уншина уу)

Гэрэлтүүлэг: Сайн гэрэлтүүлэгтэй байвал та нүдний булчингаа хэт ажиллуулж чилээх шаардлагагүй. Гэрэл хангалтгүй эсвэл хэт ойроос харж ажиллаад байвал нүд сөлийж, бүрэлзэж нүдний булчин их ядардаг. (14-р бүлэг. Гэрэлтүүлэг хэсгийг уншина уу.)

- Удирдлагаасаа шаардаж хангалттай тод гэрэлтүүлэг тавиул;
- Нүдний булчин амраах дасгалыг тогтмол хий. (111-р хуудсыг үзнэ үү)

Гал: Цахилгааны муу холболт, химийн бодисын өчүүхэн хэсэг, тоос, тамхины иш гээд олон зүйлээс болж гал гарч болзошгүй. Хувцасны үйлдвэрт галын хор, гал унтраах систем, галын гарц хангалттай биш тохиолдолд гал гарвал маш аюултай. 11-р бүлгээс галаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ, гал унтраах систем, гал гарвал хэрхэн зогсоох, үйлдвэрт байгаа ажилчдыг галын аюулаас аврах зэрэг мэдээллийг олж уншина уу.

Хаалга, цонх цоожтой байснаас түгжигджээ

2012 оны 9 дүгээр сард Пакистаны Карачи хотод байрлах “Али” аж ахуйн нэгжийн үйлдвэрт түүхэнд хамгийн харамсалтай буюу 289 хүний амь насанд хүрсэн гал гарчээ.

Уурын зуухны ойролцоо химийн бодис тархсанаас болж гал гарсан байна. Үйлдвэрийн эзэн “хулгайг зогсооно” хэмээн бүх хаалга, цонхыг түгжсэн байсан учраас галаас зугтах ямар ч боломж ажилчдад байсангүй. Үйлдвэрийн 5-р давхарт байсан ажилчид цонхоор үсрэхийг завдсан бол

(үргэлжлэл)

бусад давхарт байсан хүмүүс утаанд угаартан, галд түлэгдэн амьсгал хураажээ.

Үйлдвэр хэдхэн долоо хоногийн өмнө галаас урьдчилан сэргийлэх хөдөлмөрийн аюулгүй байдлын мэргэжлийн хяналтын байгууллагын шалгалтад хамрагдаж тэнцсэн байжээ. Мэргэжлийн хяналтын байцаагч нар аюултай нөхцөл байдлыг анзааралгүй үлдээсэн, тоогоогүй эсвэл үйлдвэрийн дарга тэдэнтэй нийлэн олон нийтийг хуурч дөнгөсөн байв. Үйлдвэр дээр өдөр тутам хяналт тавьдаг идэвхтэй ажилчид болон хөдөлмөрийн аюулгүй байдлын менежментийн хорооны хамтарсан баг нь авлигад өртөөгүй ч гэсэн хааяа нэг ирдэг мэргэжлийн хяналтын байцаагч нартай харьцуулшгүй давуу талтай юм.

Энэхүү эмгэнэлт явдлаас хойш Пакистаны 70 худалдаа, үйлдвэрлэлийн үйлдвэрчний эвлэл болон олон нийтийн байгууллага нэгдэн Ажилчдын Эрхийн хөдөлгөөнийг өрнүүлжээ. Тэд бэртсэн ажилчид болон тэдний гэр бүлд нөхөн олговор олгох шаардлага тавьж, үйлдвэрийн эзнийг баривчлуулж, үйлдвэрүүдэд хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай заалт бүхий хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд түлхэц үзүүлжээ.

Хувцас оёж дуусгах үйл явц

Хувцсыг оёж дуусгасны дараа хэд хэдэн төрлийн будалтын ажил хийдэг. Дамжлагын төгсгөлд ажилчид алдааг засаж, хувцсыг угааж, толбыг нь цэвэрлэдэг. Ингээд хатаалга, даралтад оруулж, эвхээд сүүлийн шатны тоолох, ангилах, савлах ажиллагаанд бэлддэг.

Хүчлээр угаахын хор хөнөөл

Жийнсэн хувцсыг үйлдвэрлэх сүүлийн шатны дамжлагын нэг нь уушгин чулуутай машинд угаах явц юм. Чулуу жийнсний даавууг үрж, илүү зөөлөн, хөнгөхөн болгодог. Зарим жийнсэн хувцсыг үүний дараа хүчлээр угаадаг. Ажилчид калийн перманганат, хлорын зэрэг төрөл бүрийн цайруулагчийг поролонд шингээж эсвэл шүршиж өгснөөр жийнсэн хувцас өмссөн юм шиг харагдахаар болдог байна. Эсвэл уушгин чулууг цайруулагчаар нэвт норгоод, жийнсэн хувцас угааж байгаа угаалгын машинд хийдэг байна. Заримдаа жийнсэн хувцсыг өвөрмөц загвартай болгохын тулд даавууг нь мушгиж, ороодог. (Хувцас мушгих, ороох ажлууд ихэвчлэн өрх гэрт хийгддэг. 20-р бүлэг. Үйлдвэрийн

ажлыг гэртээ хийх)

Цайруулахын тулд хүчлээр угаах нь таны арьсыг түлж, нүд, хамар, хоолойг цочроодог. Калийн перманганатын цайруулагч нь эрэгтэй, эмэгтэй хүний үр тогтоох болон төрөлтийн чадварыг бууруулж, элэг, бөөр зэрэг өөр олон эрхтнийг өвчлүүлдэг байна. 616-618 дугаар хуудаснаас дэлгэрэнгүй уншина уу.

Хэрвээ та жийнсэн хувцас цайруулах хэсэгт ажилладаг бол:

- Агааржуулагчаа хангалттай сайн байгаа эсэхийг шалга;
- Хүчлээс хамгаалах бээлий, нүүрний хаалт, хувцас хэрэглэл өмс;
- Усанд орох өрөө, анхны тусламжийн хэрэгслийг ойрхон бэлэн байлга;
- Ер нь удирдлагаасаа хүчил хэрэглэхээ болихыг шаард.

Элс шүрших үеийн аюул

Жийнсэн материалыг хөнгөхөн, зөөлхөн болгодог бас нэг арга нь ажилчид өндөр даралттай машинаар жийнсэн даавуу руу элс шүрших арга юм. Элс шүрших энэ арга ажилчдын уушгинд маш хортой байдаг учраас дэлхийн олон оронд энэ аргыг хэрэглэхийг хоригложээ. Зарим брэндүүд гар аргаар жийнсэн материалыг элсээр үрдэг байна. Хэрвээ үйлдвэрийн орчинд хангалттай хүчтэй агааржуулалтын систем байхгүй бол гараар үйлдэл хийлээ ч ялгаагүй эрүүл мэндэд сөрөг нөлөөтэйгээр барахгүй машинаар элс шүршихээс ч аюултай байж болох талтай.

Гараар элс үрэх, машинаар элс шүрших аль ч үед үйлдвэрийн ажилчид элсний ширхэг, өөрөөр хэлбэл цахиурын тоосонд өртдөг байна. Нэгэнт л цахиурын тоосоор амьсгалж, тоос уушгинд орсон бол эргэж гардаггүй. Цахиурын тоосоор амьсгалснаас болж үүсэх өвчинг силикоз гэж нэрлэдэг. Силикозоос болж амьсгал бачуурч, аутоиммун (хүний биеийн эс өөрийнхөө эдийн эсрэг үрэвсэл үүсгэх харшлын хэлбэр auto-immune), уушгины хорт хавдар зэрэг өвчин үүсэж, улмаар үхэлд хүргэнэ. Цахиурын тоосоор амьсгалснаар силикоз өвчин туссан хүнийг эдгээх эмчилгээ гэж байхгүй. Цахиурын тоосоор хордсон болон силикоз туссан хүн сүрьеэтэй хүнтэй ер нь төстэй. Навчин тамхи татах нь силикоз тусахаас ч илүү аюултай.

Жийнсэн хувцсыг элсээр шүрших, элсээр үрэх үйлдвэрт ажиллаж байгаа ажилчдын хөдөлмөр хамгааллыг хангахын тулд:

- Элсэн ширхэг гадагш тархахаас сэргийлж, ажлын байрыг битүүмжилсэн орчинд байлга;
- Элсэн ширхгийг зайлуулах хүчтэй тоос сорогчийн систем суурилуул. 329-331 дүгээр хуудсыг уншина уу;

- Ажилчдын байрлаж буй хэсгийн элсийг гадагшлуулах хүчтэй агааржуулалтын систем байрлуул. 331-332 дугаар хуудсыг үзнэ үү;
- Нэмэлт агаартай амьсгалын аппарат элс шүршдэг хэсэгт хэрэгтэй. Зөвхөн тоосноос хамгаалах амны хаалт, амьсгалын аппарат дангаараа байгаад хангалттай хамгаалж чадахгүй. 349-354 дүгээр хуудсыг уншина уу;
- Элстэй харьцах орчноос үйлдвэрийн бусад хэсэгт элсний тоос тархахгүйгээр үйлдвэрийн зураг төслийг гаргасан байх хэрэгтэй.

Одоо энэ аргыг орлуулах илүү аюул багатай аргыг үйлдвэрүүд хэрэглэдэг болжээ. Levi's зэрэг жинсэн хувцасны үйлдвэр үйлдвэрлэлдээ элс хэрэглэхээ болиод удаж байна.



Загварын чиг хандлагаас болж ажилчид амиа алдах ёсгүй!

Бидний хэдэн ажилчид бүгд өөр өөр улсаас ирсэн бөгөөд Туркт байдаг хувцасны үйлдвэрт жийнсэн материал элсээр шүрших ажил хийдэг. Бид нар цехдээ ажиллаж, тэндээ амьдардаг байлаа. Бид илүү өвөрмөц загвартай хувцас үйлдвэрлэхийн тулд жийнсэн хувцаснуудыг элсээр шүршдэг байсан юм. Элсээр шүршдэг машин маань маш хүчтэй.

Үйлдвэрийн удирдлагууд бидэнд хамгаалах хувцас, хэрэглэл гэж юу ч өгөөгүй. Бид банда хэмээх алчуур эсвэл хувцас гээд аль тааралдсан зүйлээрээ л ам, хамраа тагладаг байсан. Гэсэн ч бид нүд, гараа хамгаалдаггүй байсан. Ажлын дараа цехийнхээ хоёр давхарт гараад л унтчихдаг байсан юм.

Тун удалгүй бидний ихэнх нь амьсгалын замын өвчинд өртөж эхэллээ. Удах тусмаа бид байнга ханиалгадаг болсон байлаа. Амьсгалахад улам л хэцүү болж байсан юм. Бас олон хүн турж эхэлсэн байв. Зарим хүмүүс өвдсөн учраас харихаар буцаад явсан. Бид дахиад тэдний талаар хэзээ ч сураг ажиг сонсоогүй юм.

Цөөхөн хэд нь мэргэжлээс шалтгаалах өвчний тусгай эмнэлэгт үзүүлээд силикоз өвчтэй гэсэн оноштой ирсэн. Бидний уушги гэмтсэн учраас дахиад хэзээ ч ажиллаж, алхаж, гүйж чадахгүй болсноо ойлгоцгоосон. Гэхдээ бид бас ч гэж азтай хүмүүс байлаа. Хэдэн арван ажилчид силикозоос болж амь насаа алдсан юм. Тэд бүгдээрээ бидний таньдаг хүмүүс байсан.

Силикоз өвчнөөр өвдсөн хүмүүс маш их ууртай байлаа. Яагаад үйлдвэрийн дарга бидэнд ингэж хандаж байгаа юм бэ? Ажлаас болж хүмүүс үхэх ёсгүй! Тэгээд бид Туркт байдаг бусад ажилчидтай нэгдэж зохион байгуулалтад орж эхэлсэн юм. Дараа нь бид Цэвэр хувцас кампанит ажил (Clean Clothes Campaign) зэрэг Олон улсын байгууллагуудтай холбогдож эхэлсэн. Олон улсын байгууллагууд бидэнд зөвхөн үйлдвэрийн даргатай биш, бас тухайн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэдэг брэнд компанитай нь харьцаж шаардлага тавих хэрэгтэй гэдэг зөвлөгөө өгсөн юм. Үйлдвэрийн дарга ажилчдын өвчин туссан явдалд хариуцлага хүлээх ёстой. Гэхдээ брэнд компаниудыг элсээр шүршиж жинсэн хувцас үйлдвэрлэхийг хориглохгүй бол юу ч өөрчлөгдөхгүй. Цаашдаа энэ аймшигт өвчнөөр дахиад хүмүүс өвчлөхгүй байх баталгааг бид бий болгох ёстой. Бид эсэргүүцлээ илэрхийлж, хурал, уулзалт яриа зохион байгуулж энэ бүхний эцэст Туркийн засгийн газар улс орондоо жийнсэн материалыг элсээр шүрших технологийг хориглосон заалтыг хуульчилж өгсөн юм.

Үүний дараа бид брэндүүд рүү чиглэж ажилласан. Хүмүүс, хөдөлмөрийн чиглэлийн үйлдвэрчний эвлэл, байгууллагууд болон зарим улсын засгийн

(ургэлжлэл)

газрын дэмжлэгтэйгээр брэндүүдэд шахалт үзүүлж эхэлсэн юм. Үр дүнд нь хэд хэдэн брэндийг үйлдвэрлэлдээ элсээр шүрших аргыг хэрэглэдэггүй болгож чадсан! Гэтэл зарим компаниуд элсээр шүршихтэй яг адилхан эрүүл мэндэд хортой аргуудыг хэрэглэж эхэлсэн. Гэхдээ зүгээр. Бид энэ бүхэнд бэлэн байна. Кампанит ажил, хүчирхэг хамтын ажиллагааны тусламжтайгаар элсээр шүрших хийгээд ажилчдын эрүүл мэндэд хор хөнөөл учруулж буй аливаа үйлдвэрлэлийн аргын эсрэг тэмцэл өрнүүлсээр байх болно. Загварын чиг хандлагаас болж ажилчид амиа золиослох ёсгүй!

Даавуун хэвлэлийн хор уршиг

Зарим үйлдвэрт тусгай тавцан дээр хувцсаа тавьж будах даавуун хэвлэлийн арга ашигладаг. Энэ аргыг голдуу подволкны загвар, зураг, хээ гаргахад ашигладаг байна. Энэ төрлийн үйлдвэрлэлийн хэрэглээнд хэвлэлд ашигладаг будаг, бэх, цэвэрлэгээнд ашигладаг уусгагч бодис гээд бүгд нефтид суурилсан маш хортой бодисууд байдаг юм. Харин сүүлийн үеийн үйлдвэрүүд хүнсний ногоо болон усан суурьтай будагч, бэх, уусгагч хэрэглэж байгаа нь ажилчдын эрүүл мэндэд сөрөг нөлөө багатай байна.

Хувцсан дээр хээг хэвлэж гаргасны дараа нарийн боовны үйлдвэрүүдэд хэрэглэдэг шарах шүүгээний өндөр тавиур шиг тавиурт хувцсаа хатаадаг. Энэ машин өндөр хэмд халдаг ажээ. Ажилчдыг эрсдэлээс хамгаалахын тулд:

- Машин, тоног төхөөрөмжийг хөргөхдөө ажилчдыг ажлын байрнаас гаргах;
- Түлэгдэх аюулаас сэргийлж машины гадуур хамгаалалтын бүрхүүл хийх. (262-266 дугаар хуудсыг уншина уу);
- Ажилчдад машин, тоног төхөөрөмжийг ажиллуулах аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч, сургалт явуулах;
- Бүх машин, тоног төхөөрөмжийг цэвэрлэхийн өмнө унтрааж, түгжих горимд оруулах. (270-271 дүгээр



хуудсыг уншина уу).

Даавуун хэвлэлд хэрэглэдэг химийн бодис гал гаргах аюултайг анхаараарай.

- Галын болон хөдөлмөр хамгаалал, гал гарсан үед галыг унтраах зааварчилгаа, сургалтыг нийт ажилчдын дунд зохион байгуулах;
- Бүх химийн бодисыг металл шүүгээнд хадгал, бодис бүрт тайлбар шошго наа;
- Цэвэрлэгээ хийсэн, хэвлэлээс илүү гарсан даавууг тусгай битүүмжилсэн металл хогийн саванд хадгал.

Чанарын хяналт

Ажилчид хувцасны чанарыг шалгаж, дутуу алдаатай хэсгүүдийг гараараа нөхөж сэлбэх, оёх ажиллагаа явуулдаг. Мөн хайчлах, товч хадах зэрэг үлдсэн ажлыг ч бас хийнэ. Хувцас цэмцгэр, цэвэр харагдах асуудлыг тэд хариуцдаг.

Хэрвээ хувцас бохирдсон байвал ажилчид голдуу уусмалаар цэвэрлэдэг. Гэтэл цэвэрлэгээнд хэрэглэдэг ихэнх уусмал хүний биед хортой (дараагийн хэсэгт өгүүлнэ). Үйлдвэрийн даргаасаа хор багатай уусмал хэрэгцээндээ авах, хамгаалалтын бээлийгээр хангахыг шаардаарай. Мэдээж ажлын байрны агааржуулалт сайн байх нь хамгийн чухал зүйлсийн нэг.

Дарга нар биднийг суулгадаггүй. Зөвхөн оёдол хийдэг хүмүүс л суух эрхтэй байдаг. Дарга нарын бодлоор сууж ажиллавал хувцасны чанарын хяналтын үйл явц удаамирна гэж үздэг. Гэхдээ бидэнд сандал хэрэгтэй байна!



Дараах цэвэрлэгээний бодис ноцтой өвчлөл үүсгэдэг. Үүнд:

- Метилен хлорид уушги, элэг болон нойр булчирхайн хорт хавдар үүсгэдэг;
- Тетрахлорэтилен (PERC) элэг болон бөөрний хорт хавдар үүсгэдэг;
- Трихлорэтилен (TCE) элгийг гэмтээж, хорт хавдар үүсгэх аюултай;
- Толуол төрөлтийн гажиг үүсгэж, бөөр, элгийг гэмтээдэг бөгөөд галд амархан шатамхай бодис юм;
- Трихлорэтан (TCA эсвэл метил хлороформ) мэдрэлийн системийг гэмтээдэг.

Эдгээр бодис хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөг харьцангуй бага үзүүлдэг боловч галд шатамхай бодис юм.

- Ацетон нүд, хамрыг цочроодог;
- Этанол (этилийн спирт) нүд, хамрыг цочроодог;
- Изопропилийн спирт (изопропанол) нүд, хамрыг цочроодог.

Ажилчдаа дараах байдлаар хамгаал.

- Хүний биед хор багатай химийн бодис, үйлдвэрлэлийн аргыг хэрэглэ;
- Бүх химийн бодист тайлбар шошго хийж, ажилчдад үйлдвэрийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг тэдний ойлгох хэлээр тайлбарлаж, химийн бодисыг хэрхэн өөртөө аюулгүй байдлаар хэрэглэх талаар сургалт явуул;
- Хортой химийн бодисыг усан суурьтай өөр бодисоор орлуул.

Илүү дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт Б-д оруулсан болно.

Хатаалга болон индүүдлэг



Хувцасны үйлдвэрийн хог хаягдал

Хувцасны үйлдвэрүүд ихэвчлэн үйлдвэрлэлийн янз бүрийн бүсэд байрладаг. Хувцасны үйлдвэрээс гарсан хогийг шатаах эсвэл шууд л газарт хаядаг. Харин химийн бодисууд нь агаар, усыг бохирдуулдаг байна. Нэмэлт мэдээллийг 33-р бүлэг. Үйлдвэрийн хог хаягдал хэсгээс уншина уу.

Урсгал ус цайвар цэнхэр өнгөтэй болчихлоо!

Африкийн Лесото хотын удирдлагууд дэлхийн томоохон брэндүүдийг үйлдвэрээ хотод нь барихыг урьжээ. Гар болон Levi's брэнд үйлдвэрээ нээж, олон хүн ажлын байртай болсондоо баяртай байлаа.

(ургэлжлэл)

Жийнсэн хувцас хийхэд маш их хог хаягдал гардаг. Тэр их хог хаягдлын ихэнхийг дахин боловсруулах боломжгүй байдаг. Бохирдсон даавууг арчлах, угаах, зайлах зэрэг ажиллагаанд ус хэрэглэдэг. Түүнчлэн машин, тоног төхөөрөмж, оффисын цэвэрлэгээнээс асар их хог, хуванцар, цаас гардаг байна.

Компанийн удирдлагууд хог хаягдлаа цуглуулж янзалдаг гэж хэлцгээдэг. Гэтэл Лесото хотод хог хаягдлын асуудлыг шийдвэрлэх ямар ч механизм байхгүй. Тэд зүгээр л хогоо шууд нууранд хаяж, ундны усны урсгалыг бохирдуулдаг.

Үйлдвэрээс хаяж байгаа хогонд даавуу, зүү, химийн бодисын сав суулга гээд есөн шидийн юм бий. Бас хүмүүс үйлдвэрийн хог хаягдал дээр очиж хэрэглэж болох, зарж болох юу л байна авдаг. Хүүхдүүд химийн бодисын сав суулгыг гэртээ ус хийдэг сав болгохоор авчирдаг. Зарим нь зүү, багаж хэрэгсэл ч олж авдаг. Айлын эзэгтэй нар даавуун алчууруудыг шатааж хоол ундаа хийдэг. Тэр шатааж байгаа даавуу нь химийн хортой гэдгийг мэддэггүй. Тэгээд шатаах болгонд хоол унд, агаараа бохирдуулсаар л байдаг.

Удалгүй усны урсгал цэнхэр өнгөтэй болж эхэлсэн. Цайвар цэнхэр! Энэ усаар бид тариан талбайгаа усалдаг. Бүх будагч бодис, химийн бодис зүгээр л шууд бидний иддэг хоол хүнс рүү орж байна.

Олон нийтийн дундаас нэг удирдагч гэрэл зурагчнаас эдгээр хог хаягдлыг зургийг авч өгөхийг хүслээ. Энэ зургуудаа интернэтэд тавьсны дараа бид асар олон хандалт авсан юм. Сэтгүүл, сонины сурвалжлагчид ирж дэлхий дахинд юу болоод байгааг мэдээлж эхэллээ. Гар болон Levi's –ын удирдлагууд ч бас ирсэн. Тэдгээр удирдлагууд “Ийм зүйл болсныг огт мэдээгүй, ийм зүйл болох ёсгүй шүү дээ” л гэцгээж байв. Ингээд үйлдвэрийг цэвэрлэсэн юм. Гэхдээ бид одоо хүртэл тэд яаж хог хаягдлаа багасгах, одоо хаячихаад байгаа өчнөөн хогоо яаж шийдвэрлэхийг нь хүлээсээр л байна.